

Дундаж цалин хөлс тодорхойлох журамд нэмэлт оруулсныг 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөнө.

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд (“ХНХС”) 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн тушаалаар Дундаж цалин хөлс тодорхойлох журамд (“Дундаж цалин хөлс тодорхойлох журам”) нэмэлт оруулсан бөгөөд энэхүү нэмэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө (“Журмын нэмэлт”). Журмын нэмэлтийг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэсэн байна.

Дундаж цалин хөлс тодорхойлох журам нь илүү цагийн, шөнийн цагаар ажилласны болон бусад нэмэгдэл хөлс, хуулиар тогтоосон бусад олговор зэргийг тооцоход хамаарах хугацаа, цалин хөлсний бүрэлдэхүүнийг тодорхойлоход гол ач холбогдолтой. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Дундаж цалин хөлс тодорхойлох журам хэрэгжиж эхэлснээр Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлсийг тухайн ажилтны өмнөх 3 сарын дундаж цалин хөлсөөр тооцож олгохоор болсон бөгөөд цалин хөлсний бүрэлдэхүүнд 1) үндсэн цалин; 2) нэмэгдэл; 3) нэмэгдэл хөлс; 4) ээлжийн амралтын цалин; 5) шагнал урамшуулалыг оруулахаар заасан.

Дундаж цалин хөлс тодорхойлох энэхүү шинэ аргачлал хэрэгжиж эхэлснээр ээлж/уртын ээлжийн хуваариар ажилладаг ажилтны ажлын гүйцэтгэл, ажиллах цагт өөрчлөлт ороогүй, нэмэгдээгүй байхад ажилчдын цалин зогсолтгүй, зохиомлоор өсөх үр дагавар үүссэнтэй холбогдуулан уг журмыг ажил олгогчдын зүгээс нэлээдгүй шүүмжлэлтэй хүлээн авсан. ХНХС-ын зүгээс ажил олгогчдод үзүүлж буй энэхүү сөрөг үр дагаврыг зохицуулах зорилгоор энэхүү Журмын нэмэлтийг баталсан гэж бид ойлгож байна.



Юу өөрчлөгдсөн бэ ?

Журмын нэмэлтэд заасны дагуу нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо **цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг** оруулахгүй байж болохоор тусгажээ. Энэ тохиолдолд цалин хөлсний бүрэлдэхүүнд зөвхөн 1) үндсэн цалин, 2) нэмэгдэл, 3) ээлжийн амралтын цалинг оруулан тооцох боломжтой болж байна.

Журмын нэмэлт нь буцаж үйлчлэхгүй.

Дундаж цалин хөлс тодорхойлох журам, Журмын нэмэлтийн үйлчлэлийг доорх зургаар харуулав.

Өмнөх дундаж цалин хөлс тодорхойлох журам

Журмын нэмэлт үйлчилнэ

2022 1 сар 2 3 4 5 6 7 8 9 10



Журмын нэмэлтийн талаар болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол та бидэнтэй холбоо барина уу.

Дараах линкээр орж Журмын Нэмэлттэй танилцана уу.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468248973651&showType=1>



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК болон ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-г илэрхийлнэ.